

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр  
сарын .... -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Нарийн сухайт эрчим” ХХК-ийн 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 2026/104 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Ноён, Сэврэй, Гурван тэс сумдын импортын цахилгаан эрчим хүчээр хангагдаж буй хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Нарийн сухайт эрчим” ХХК (Ц.Жаргалсайхан), “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (Т.Жаргалсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоол, 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 369 дүгээр тогтоол, 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 403 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар (Б.Эрдэнэбулган)-г даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

*Эрчим хүчний зохицуулах хорооны*

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН, СЭВРЭЙ, ГУРВАН ТЭС СУМДЫН  
ИМПОРТЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАГДАЖ БУЙ ХЭРЭГЛЭГЧДЭД  
БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж болон бусад байгууллага, айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

<b>№</b>	<b>Ангилал</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тариф</b>
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж, байгууллага Үүнд: <i>Нүүрс олборлолт, боловсруулалт Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт Банк, банкны нэгж Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Криптовалют олборлох, үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч</i>	төг/кВт.ц	514.55
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/кВт.ц	309.98
3	Айл өрх	төг/кВт.ц	256.00